

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УИХ	Улсын Их Хурал
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	10
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	13
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	17
3.Аудитын тайлан.....	19
3.1. Ерөнхий зүйл.....	19
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	19
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	20
3.4. Материаллаг байдал	20
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	21
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	23
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	24
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	25
3.9. Аудитын илрүүлэлт.....	25
Залруулсан алдаа.....	25
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	25
Аудитын зөвлөмж.....	27
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	27
4. Менежментийн захидал	28
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	31



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ
ЭМНЭЛГИЙН ЗАХИРАЛ
Я.АМАРЖАРГАЛ ТАНАА

2021.08.25 № 07/522
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурьдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага нь бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторов тайлангаас бусад санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Аудитын гол асуудал

1. Үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 896,074.2 мянган төгрөгөөр тасарсан, нэмэлт төсвийн 4,441.7 мянган төгрөгийг нээсэн эрхийн дагуу зарцуулаагүй;
2. Эрүүл мэндийн даатгалын сангаас хасч тооцсон 41,429.6 мянган төгрөгийг орлого бууруулан бүртгэж, хэвтэн эмчлүүлэгсдийн төлбөр 3,021.1 мянган төгрөгийг тус тус орлогоор хүлээн зөвшөөрөөгүй, авлагаар тайлагнаагүй;

3. Урсгал төсвөөс худалдан авсан 210,627.8 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэхдээ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл аваагүй, 2019 оны 12 дугаар сараас ашиглаж байгаа дүн бүртгэлийн Карте программыг орлого аваагүй, бүртгэлтэй 67,671.8 мянган төгрөгийн 11 программыг ашигладаггүй;
4. Шилэн дансны цахим сайтад 2020 оны 8 дугаар сард эрх нь нээгдсэн цэсэнд Ковидтай холбоотой 187,300.0 мянган төгрөгийн мөнгөн хандив тусламжийн орлого, 222,330.3 мянган төгрөгийн материаллаг хандив, тусламжийн орлого, нийт 406,593.3 мянган төгрөгийн зарцуулалтын 1-9 сарын мэдээнүүдийг хугацаа хоцроож, 10 дугаар сард нөхөн оруулсан зэрэг зөрчлүүд нь холбогдох хууль, тогтоомжийн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,528,810,916.01	3,277,954,236.18
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	10,000.00	10,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	10,000.00	10,000.00
3121	Төгрөг	10,000.00	10,000.00
31213	Арилжааны банк дахь харилцах	10,000.00	10,000.00
33	АВЛАГА	1,785,949.00	1,681,568.92
33100	Ажилчидтай холбогдсон авлага	-	1,681,568.92
335	Бусад авлага	1,785,949.00	-
3351	Байгууллагаас авах авлага	1,785,949.00	-
34	УРЬДЧИЛГАА	-	528,933,135.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	332,800.00
3471	Урьдчилгаа тооцоо	-	528,600,335.00
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	-	528,600,335.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,527,014,967.01	2,747,329,532.26
351	Түүхий эд материал	380,107,913.33	1,315,484,323.29
35110	Тусгай зориулалттай материал	11,163,860.00	15,908,678.00
35130	Эм боох материал	368,944,053.33	1,299,575,645.29
354	Хангамжийн материал	1,146,907,053.68	1,431,845,208.97
35410	Бичиг хэргийн материал	6,913,966.20	22,244,839.00
35420	Аж ахуйн материал	43,855,672.77	39,568,600.50
35430	Сэлбэг хэрэгсэл	-	360,885.00
35440	Түлш, шатах тослох материал	6,678,327.60	4,857,477.01
35450	Барилгын засварын материал	3,245,152.50	3,350,081.79
35460	Хүнсний материал	33,009,102.43	13,212,237.59
35470	Бусад хангамжийн материал	1,053,204,832.18	1,348,251,088.08
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	11,505,453,498.84	13,627,296,089.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	11,505,453,498.84	13,627,296,089.00
392	Биет хөрөнгө	9,988,602,211.10	12,115,855,039.54
39201	Барилга, байгууламж, орон сууц	7,215,497,759.35	7,649,814,758.35
39202	Хуримтлагдсан элэгдэл	(553,702,830.30)	(1,127,038,028.70)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	263,814,659.00	273,713,819.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(220,075,359.87)	(204,704,217.97)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	7,588,455,514.28	10,459,750,870.58
39206	Хуримтлагдсан элэгдэл	(5,586,221,309.18)	(6,089,304,985.74)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	2,355,365,903.06	2,415,603,348.76
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,200,071,098.53)	(1,374,476,715.50)
39214	Бусад үндсэн хөрөнгө	206,645,859.00	212,695,859.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(81,106,885.71)	(100,199,668.24)
393	Биет бус хөрөнгө	1,516,851,287.74	1,511,441,049.46
39301	Програм хангамж	93,062,350.00	93,421,225.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(81,136,322.26)	(86,905,435.54)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,504,925,260.00	1,504,925,260.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	13,034,264,414.85	16,905,250,325.18
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	31,228,449.00	20,588,708.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	31,228,449.00	20,588,708.00
413	Өглөг	2,004,449.00	3,372,708.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,003,449.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	2,394,595.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,000.00	978,113.00
414	Урьдчилж орсон орлого	29,224,000.00	17,216,000.00
41430	Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	-	3,136,000.00

41440	Бусад урьдчилж орсон орлого	29,224,000.00	14,080,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	13,003,035,965.85	16,884,661,617.18
51	Засгийн газрын хувь оролцоо	13,003,035,965.85	16,884,661,617.18
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	11,941,287,076.42	11,941,287,076.42
51101	Өмч: - төрийн	11,941,287,076.42	11,941,287,076.42
512	Хуримтлагдсан үр дүн	(3,910,041,343.13)	(28,415,691.80)
51210	Өмнөх үеийн үр дүн	(5,945,548,046.05)	(3,569,233,760.13)
51220	Тайлант үеийн үр дүн	2,035,506,702.92	3,540,818,068.33
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	-	-
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,971,790,232.56	4,971,790,232.56
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	13,034,264,414.85	16,905,250,325.18

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	17,615,374,744.34	23,813,998,240.49
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,833,787,136.34	6,540,619,449.49
120	Нийтлэг татварын бус орлого	1,756,935,227.50	2,330,542,868.54
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,725,194,427.50	2,330,542,868.54
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,613,333,013.05	2,128,103,222.50
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	111,861,414.45	202,439,646.04
120005	Түрээсийн орлого	31,740,800.00	-
120	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,076,851,908.84	4,210,076,580.95
120017	Үнэ төлбөргүй бараа материал	2,715,831,505.09	1,351,684,912.52
120018	Үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө	361,020,403.75	2,858,391,668.43
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	12,781,587,608.00	17,273,378,791.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,236,572,300.00	6,228,510,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,154,190,700.00	6,228,510,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	82,381,600.00	374,496,550.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	10,352,200.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,422,400.00	236,496,550.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий олсон нэмэлт орлого	31,607,000.00	138,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	8,545,015,308.00	10,670,372,141.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангин төсвөөс санхүүжих	8,545,015,308.00	10,670,372,141.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	15,579,136,304.24	20,269,619,842.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,579,136,304.24	20,269,619,842.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,461,364,140.89	19,915,564,785.48
2101	Цалин хөлс болон нэмэглэо урамшил	5,740,839,317.00	7,612,924,305.91
210101	Үндсэн цалин	3,394,145,704.00	4,475,583,519.41
210102	Нэмэгдэл цалин	1,510,258,369.00	1,997,711,527.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	463,934,000.00	548,681,000.00

210104	Урамшуулал	372,501,244.00	590,948,259.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	726,328,206.00	960,394,345.04
210201	Тэтгэврийн даатгал	615,988,483.00	828,569,769.00
210205	Эрүүл мэндийн даатгал	110,339,723.00	131,824,576.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	446,790,458.75	916,024,830.10
210301	Гэрэл цахилгаан	185,683,445.00	510,851,940.04
210302	Түлш, халаалт	160,195,168.21	236,701,199.04
210303	Цэвэр, бохир ус	100,911,845.54	168,471,691.02
2104	Хангамж, бараа материалын зардал	456,579,487.93	659,586,526.54
210401	Бичиг хэрэг	55,547,016.09	58,187,837.20
210402	Тээвэр шатахуун	31,573,661.73	28,205,234.32
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	14,239,120.00	16,352,976.76
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	161,815,731.49	203,126,231.98
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	193,403,958.62	353,714,246.28
2105	Норматив зардал	6,399,754,423.54	7,980,530,302.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	6,077,147,648.35	7,540,590,869.44
210502	Хоол, хүнс	239,261,578.19	226,814,815.11
210503	Нормын болон дүрэмт хувцас, зөөлөн эдлэл	83,345,197.00	213,124,617.65
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	339,760,456.72	190,053,690.20
210604	Урсгал засвар	339,760,456.72	190,053,690.20
2107	Томилолт, зочны зардал	11,839,629.00	6,087,350.00
210701	Гадаад албан томилолт	5,708,362.00	-
210702	Дотоод албан томилолт	6,131,267.00	6,087,350.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,732,166.00	126,266,450.90
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	81,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,000,000.00	7,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	534,600.00	528,660.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	690,986.00	715,770.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	187,000.00	189,178.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	26,539,512.90

210807	Газрын төлбөр	9,760,170.00	9,753,030.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	559,410.00	540,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,319,739,995.95	1,463,696,984.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	66,714,708.70	39,272,885.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	20,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	1,253,025,287.25	1,404,424,099.59
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	117,772,163.35	354,055,057.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	98,933,977.00	335,316,882.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	76,602,474.00	312,029,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	22,331,503.00	23,287,382.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,838,186.35	18,738,175.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,838,186.35	18,738,175.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮД ДҮН (3)=(1)-(2)	2,036,238,440.10	3,544,378,398.01
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	731,737.18	3,560,329.68
225001	Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	731,737.18	3,560,329.68
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(731,737.18)	(3,560,329.68)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,035,506,702.92	3,540,818,068.33

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
0	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	14,584,023,544.05	19,584,549,426.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,302,451,244.05	12,981,542,776.50
120	Нийтлэг татварын бус орлого	1,757,435,936.05	2,311,170,635.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,757,435,936.05	2,311,170,635.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,617,682,113.05	2,129,786,614.50
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	139,753,823.00	181,384,021.00
122	Тусламжийн орлого	8,545,015,308.00	10,670,372,141.00
122001	ЭМД-ын санхүүжилт	8,545,015,308.00	10,670,372,141.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮГИЙН ОРЛОГО	4,281,572,300.00	6,603,006,650.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,154,190,700.00	6,228,510,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,154,190,700.00	6,228,510,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	127,381,600.00	374,496,550.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	10,352,200.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	85,422,400.00	236,496,550.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	31,607,000.00	138,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,555,015,044.05	19,253,921,658.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,555,015,044.05	19,253,921,658.50
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,448,629,383.70	18,905,293,230.50
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	5,623,429,995.00	7,548,026,331.91
210101	Үндсэн цалин	3,474,625,051.00	4,508,878,854.48
210102	Нэмэгдэл	1,306,592,700.00	1,863,702,509.97
210103	Унаа хоолны хөнгөлөлт	509,451,000.00	537,797,868.24
210104	Урамшуулал	332,761,244.00	637,647,099.22
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	-

210201	Тэтгэврийн даатгал	724,380,326.00	959,579,267.04
210202	Тэтгэмжийн даатгал	501,607,706.00	660,286,377.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	59,467,548.00	77,703,444.09
210204	Ажилгүйдлийн даатгал	46,798,758.00	60,134,992.23
210205	Эрүүл мэндийн даатгал	10,803,246.00	14,837,964.65
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	105,703,068.00	146,616,488.60
210301	Гэрэл, цахилгаан	446,790,458.75	916,024,830.10
210302	Түлш, халаалт	185,683,445.00	510,851,940.04
210303	Цэвэр, бохир ус	160,195,168.21	236,701,199.04
2104	Хангамж, бараа материалын зардал	100,911,845.54	168,471,691.02
210401	Бичиг хэрэг	226,329,559.00	269,216,147.76
210402	Тээвэр, шатахуун	9,429,418.00	15,150,210.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	33,510,600.00	26,155,000.00
210404	Ном, хэвлэл	13,789,120.00	16,648,794.26
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,962,700.00	18,172,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	124,964,964.00	153,493,244.50
2105	Норматив зардал	32,672,757.00	39,596,499.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,525,501,951.95	4,131,867,821.44
210502	Хоол, хүнс	3,051,399,551.95	3,653,078,294.14
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	360,230,300.00	338,311,587.30
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	113,872,100.00	140,477,940.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	328,296,900.00	670,588,718.00
210602	Тавилга	9,692,700.00	532,387,813.00
210604	Урсгал засвар	4,524,900.00	400,000.00
2107	Томилолт, зочны зардал	314,079,300.00	137,800,905.00
210701	Гадаад албан томилолт	5,381,500.00	6,087,350.00
210702	Дотоод албан томилолт	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,381,500.00	6,087,350.00
210801	Бусдаар гүйцтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	152,776,666.00	146,175,444.75
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	78,140,000.00	96,000,000.00

210803	Даатгалын үйлчилгээ	8,000,000.00	7,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	534,600.00	528,660.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	690,986.00	705,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	187,000.00	189,178.00
210807	Газрын төлбөр	35,000,000.00	10,518,176.75
210808	Банк санхүүгийн үйлчилгээний хураамж	9,760,170.00	9,753,030.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	919,410.00	1,686,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,544,500.00	19,794,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,415,047,027.00	4,257,727,319.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,374,283,527.00	4,218,465,448.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,763,500.00	39,261,871.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	107,080,660.35	348,628,428.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	88,242,474.00	329,890,253.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	430,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	76,602,474.00	312,029,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,210,000.00	17,860,753.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,838,186.35	18,738,175.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	18,838,186.35	18,738,175.00
0	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	29,008,500.00	330,627,768.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	29,007,500.00	330,627,768.00
2200	Дотоод эх үүсвэрээр	29,007,500.00	330,627,768.00
222001	Тоног төхөөрөмж	-	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	120,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	29,007,500.00	210,627,768.00
0	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН	(29,007,500.00)	(330,627,768.00)
7	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,000.00	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,000.00	10,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон				
				(төгрөгөөр)
ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	11,941,287,076.42	4,971,790,232.56	(5,944,118,046.05)	10,968,959,262.93
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(1,430,000.00)	(1,430,000.00)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,941,287,076.42	4,971,790,232.56	(5,945,548,046.05)	10,967,529,262.93
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	2,035,506,702.92	2,035,506,702.92
2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	11,941,287,076.42	4,971,790,232.56	(3,910,041,343.13)	13,003,035,965.85
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	340,807,583.00	340,807,583.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,941,287,076.42	4,971,790,232.56	(3,569,233,760.13)	13,343,843,548.85
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	3,540,818,068.33	3,540,818,068.33
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	11,941,287,076.42	4,971,790,232.56	(28,415,691.80)	16,884,661,617.18

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон				
			(төгрөгөөр)	
Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	10,000.00	-	-
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	21,753,429,400.00	19,191,314,701.50	2,562,114,698.50	88.2
УРСГАЛ ЗАРДАЛ	21,753,429,400.00	19,191,314,701.50	2,562,114,698.50	88.2
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,127,916,700.00	18,862,614,448.50	(3,734,697,748.50)	124.7
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	7,863,489,700.00	7,490,560,826.91	372,928,873.09	95.3
Үндсэн цалин	4,486,760,400.00	4,488,713,349.48	(1,952,949.48)	100.0
Нэмэгдэл цалин	2,036,537,100.00	1,844,402,509.97	192,134,590.03	90.6
Унаа хоолны хөнгөлөлт	652,785,000.00	537,797,868.24	114,987,131.76	82.4
Урамшуулал	687,407,200.00	619,647,099.22	67,760,100.78	90.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,075,161,800.00	959,579,267.04	115,582,532.96	89.3
Тэтгэврийн даатгал	756,859,000.00	660,286,377.47	96,572,622.53	87.2
Тэтгэмжийн даатгал	79,575,700.00	77,703,444.09	1,872,255.91	97.7
ҮОМШӨ-ний даатгал	63,660,600.00	60,134,992.23	3,525,607.77	94.5
Ажилгүйдлийн даатгал	15,915,100.00	14,837,964.65	1,077,135.35	93.2
Эрүүл мэндийн даатгал	159,151,400.00	146,616,488.60	12,534,911.40	92.1
Бараа, үйлчилгээний зардал	6,189,265,200.00	5,191,238,620.05	998,026,579.95	83.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	954,325,200.00	916,024,830.10	38,300,369.90	96.0
Гэрэл, цахилгаан	409,383,000.00	510,851,940.04	(101,468,940.04)	124.8
Түлш, халаалт	312,000,000.00	236,701,199.04	75,298,800.96	75.9
Цэвэр, бохир ус	232,942,200.00	168,471,691.02	64,470,508.98	72.3
Хангамж, бараа материалын зардал	251,093,200.00	226,701,075.76	24,392,124.24	90.3
Бичиг хэрэг	13,800,300.00	14,359,210.00	(558,910.00)	104.1
Тээвэр, шатахуун	30,537,800.00	26,155,000.00	4,382,800.00	85.7
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,492,400.00	16,648,794.26	843,605.74	95.2
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	175,856,400.00	153,493,244.50	22,363,155.50	87.3
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,406,300.00	16,044,827.00	(2,638,527.00)	119.7
Норматив зардал	4,064,591,900.00	3,139,101,371.44	925,490,528.56	77.2

Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,451,208,000.00	2,664,311,844.14	786,896,155.86	77.2
Хоол, хүнс	443,217,600.00	334,311,587.30	108,906,012.70	75.4
Нормын хувцас, зөөлөн эдлэл	170,166,300.00	140,477,940.00	29,688,360.00	82.6
Эд хогшил, урсгал засварын зардал	855,644,000.00	853,148,548.00	2,495,452.00	99.7
Багаж, техник, хэрэгсэл	735,361,600.00	717,647,643.00	17,713,957.00	97.6
Тавилга	9,397,000.00	4,000,000.00	5,397,000.00	42.6
Урсгал засвар	110,885,400.00	135,100,905.00	(24,215,505.00)	121.8
Томилолт, зочны зардал	7,682,400.00	6,087,350.00	1,595,050.00	79.2
Дотоод албан томилолт	7,682,400.00	6,087,350.00	1,595,050.00	79.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	55,928,500.00	50,175,444.50	5,753,055.50	89.7
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	-	-	
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,000,000.00	7,000,000.00	1,000,000.00	87.5
Даатгалын үйлчилгээ	560,000.00	528,660.00	31,340.00	94.4
Тээврийн хэрэгслийн татвар	705,600.00	705,600.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн оношилгоо	220,000.00	189,178.00	30,822.00	86.0
Мэдээлэл технологи	14,114,600.00	10,518,176.75	3,596,423.25	74.5
Газрын төлбөр	9,760,200.00	9,753,030.00	7,170.00	99.9
Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,773,600.00	1,686,300.00	1,087,300.00	60.8
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	19,794,500.00	19,794,500.00	-	100.0
Хичээл үйлдвэрлэл, дадлага	20,000,000.00	1,908,111.00	18,091,889.00	9.5
Хичээл үйлдвэрлэл, дадлага	20,000,000.00	1,908,111.00	18,091,889.00	9.5
80103 Гэрээгээр гүйцэтгэх ажил	35,000,000.00	8,750,000.00	26,250,000.00	25.0
Урсгал засвар	35,000,000.00	8,750,000.00	26,250,000.00	25.0
80219 Гэрээт харуул цалин	81,000,000.00	81,000,000.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	81,000,000.00	81,000,000.00	-	100.0
81601 Өндөр өртөгт эм эмнэлгийн хэрэгсэл	5,130,186,300.00	4,098,960,723.50	1,031,225,576.50	79.9
Өндөр өртөгт эм эмнэлгийн хэрэгсэл	5,130,186,300.00	4,098,960,723.50	1,031,225,576.50	79.9
81611 Нормативт зардал	910,753,300.00	910,753,300.00	-	100.0
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	910,753,300.00	910,753,300.00	-	100.0

83112 Хөтөлбөр дотоод урсгал зардал	119,863,600.00	119,863,600.00	-	100.0
Хөтөлбөр төслийн болон дотоод урсгал зардал	119,863,600.00	119,863,600.00	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	328,709,500.00	328,700,523.00	8,977.00	100.0
Тэтгэвэрт гарахад олгох 1 удаа тэтгэмж	312,029,500.00	312,029,500.00	-	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,680,000.00	16,670,753.00	9,247.00	99.9
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	21,753,429,400.00	19,191,314,701.50	2,562,114,698.50	88.2
ЭМД Санхүүжилт	12,291,424,500.00	10,670,372,141.00	1,621,052,359.00	86.8
Эмнэлгийн тусламж үйлчилгээний ЭМДС	8,241,284,200.00	7,395,115,862.00	846,168,338.00	89.7
Өндөр өртөг бүхий ЭМДС	4,050,140,300.00	3,275,256,279.00	774,884,021.00	80.9
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	6,254,760,100.00	6,209,771,925.00	44,988,175.00	99.3
Урсгал зардал	4,779,433,700.00	4,760,695,525.00	18,738,175.00	99.6
Урсгал зардал	35,000,000.00	8,750,000.00	26,250,000.00	25.0
Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	81,000,000.00	81,000,000.00	-	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	328,709,500.00	328,709,500.00	-	100.0
Төр даах эм, эмнэлгийн хэрэгсэл санхүүжилт	910,753,300.00	910,753,300.00	-	100.0
Бараа үйлчилгээний зардал	119,863,600.00	119,863,600.00	-	100.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	3,207,244,800.00	2,311,170,635.50	896,074,164.50	72.1
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,077,068,800.00	2,129,786,614.50	947,282,185.50	69.2
Эмнэлгийн тусламж үйлчилгээний орлого	1,997,022,800.00	1,306,082,170.00	690,940,630.00	65.4
Өндөр өртөг бүхий мэс заслын хувь төлөх орлого	1,080,046,000.00	823,704,444.50	256,341,555.50	76.3
Туслах үйл ажиллагааны орлогоос	130,176,000.00	181,384,021.00	(51,208,021.00)	139.3
Нэр данс зөрүү	-	-	-	
Тендерийн орлого	-	-	-	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	10,000.00	(10,000.00)	
Ажиллагсдын тоо	570	564	6	
Удирдах ажилтан	4	4	-	
Гүйцэтгэх ажилтан	413	413	-	
Үйлчлэх ажилтан	153	147	6	
Гэрээт ажилтан	-	-	-	

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Үзүүлэлт	Төлөвлөгөө	(төгрөгөөр) Гүйцэтгэл
Орлогын дүн	374,496,550.00	374,496,550.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	168,000,000.00	168,000,000.00
ЗГ хоорондын гэрээ болон ОУ-д байгууллагаас авах хөнгөлттэй зээл		
ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
Бусад төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан хөрөнгө		
Дээд шатны төсвийг захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчдад хувиарилсан хөрөнгө	206,496,550.00	206,496,550.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		
Төсвийн урамшуулал		
Нийт зарлагын дүн	374,496,550.00	374,496,550.00
Урсгал зардлын дүн	254,496,550.00	254,496,550.00
Бараа үйлчилгээний зардал	57,465,505.00	57,465,505.00
Үндсэн цалин	20,165,505.00	20,165,505.00
Нэмэгдэл	19,300,000.00	19,300,000.00
Урамшуулал	18,000,000.00	18,000,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	195,841,045.00	195,841,045.00
Гэрэл цахилгааны		
Түлш халаалтын		
Цэвэр, бохир усны		
Бичиг хэрэг	791,000.00	791,000.00
Тээвэр шатахуун		
Ном хэвлэл	18,172,400.00	18,172,400.00
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	30,019,935.00	30,019,935.00
Эмийн зардал	78,013,150.00	78,013,150.00
Хоолны зардал	4,000,000.00	4,000,000.00
Багаж хэрэгсэл	12,490,800.00	12,490,800.00
Тавилга		
Урсгал засвар		
Гадаад томилолт		
Дотоод томилолт		
Бусад нийтлэг АҮТөлбөр хураамж	15,000,000.00	15,000,000.00
Мэдээлэл технологийн үйлчилгээ		

Хичээл үйлдвэрлэлийн дадлага	37,353,760.00	37,353,760.00
Татан төвлөрүүлэлт		
Татаас ба урсгал шилжүүлэг	1,190,000.00	1,190,000.00
Нэг удаагийн тэтгэмж	1,190,000.00	1,190,000.00
Тоног төхөөрөмж	120,000,000.00	120,000,000.00
Тоног төхөөрөмж	120,000,000.00	120,000,000.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Улсын хоёрдугаар төв эмнэлгийн захирал Я.Амаржаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн бодлогыг өөрийн байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлагналд нийцүүлэн сайжруулах, нягтлан бодох бүртгэл болон дүн бүртгэлийн программ хангамжуудын ашиглалтыг сайжруулах, худалдан авах ажиллагааны анхан шатны баримт бүрдүүлэлт, тайлан мэдээнүүдийн уялдаа холбоог сайжруулж, холбогдох ажилтнуудын үүрэг хариуцлагыг сайжруулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн захирал Н.Дэлгэрмаа удирдан, аудитор И.Солонго, С.Цэнгэлмаа аудиторовын туслах Ө.Гантулга, Б. Өнөболд нар хариуцаж хэрэгжүүлэв.

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 6/51 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Улсын хоёрдугаар төв эмнэлэг нь дэвшилтэт технологи, чадварлаг эмч, мэргэжилтний багаар олон улсын чанар, аюулгүй байдлын стандартыг хангасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үйлчлүүлэгч бүрт хүргэх эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл, зорилтоо тодорхойлон ажиллаж байна.

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Эмнэлгийн анхан шатны, үндсэн, төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээг төрийн, улс төрийн болон төрийн өндөр албан тушаалтнуудад үзүүлнэ
2. Төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээг үйлчлэх хүрээний албан тушаалтан, иргэдэд үзүүлнэ.
3. Мэс заслын тусламж үйлчилгээг Сүхбаатар дүүргийн иргэдэд үзүүлнэ

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх дараах хууль, тогтоомж, бодлого, журам шинээр батлагдан гарсан байна. Үүнд:

- УИХ-аас 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр баталсан Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 30 дугаар тогтоолоор баталсан Шинэ Коронавирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай журам

- Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 78 дугаар тогтоолоор баталсан Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай журам
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 08-ны өдрийн 10 дугаар тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай журам
- Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 114 дүгээр тогтоолоор баталсан Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай журам

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус эмнэлгийн даргын 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/98 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлагналд нийцээгүй байна.

Эрүүл мэндийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас тус байгууллагын 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй ба харин Эрүүл мэндийн яамны Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газарт шилэн дансны улирал тутмын мэдээг албан бичгээр хүргүүлж ажиллажээ. Шилэн дансны мэдээллийн үнэн зөв байдлыг дүгнэж, хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар зөвлөмж шаардлага өгөөгүй байна.

Санхүү бүртгэлийн албаны дотоод хяналтын 2020 оны ажлын төлөвлөгөөнд 7 ажлыг гүйцэтгэхээр тусган эмнэлгийн даргаар батлуулсан байна. Тайлант онд батлагдсан төлөвлөгөөний дагуу санхүү, бүртгэлийн дотоод хяналт гүйцэтгэсэн талаар батлагдаагүй 2 тайлан ирүүлсэн бөгөөд шалгалтын үр дүнг баталгаажуулаагүй, алба, тасаг нэгж, албан тушаалтанд хариуцлага тооцсон тушаал танилцуулаагүй, шалгалтын мөрөөр зохиосон үйл ажиллагааны тайлан, баримт материалгүй байна.

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны 3 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “ДУНД” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 8,446,538.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 84,465.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тогтоож, баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, 202,731.8 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон нь тайлант оны нийт зардлыг аудитад хамруулах үүднээс суурь үзүүлэлтийн дүнг гүйцэтгэлийн үе шатанд өөрчилсөн.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,870,986.0 мянган төгрөгөөр буюу 29.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урьдчилгаа тооцоо, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	10.0	10.0	-
Авлага	1,785.9	1,681.6	(104.3)
Урьдчилгаа	-	528,933.1	528,933.1
Бараа материал	1,527,014.9	2,747,329.5	1,220,314.6
Үндсэн хөрөнгө	19,134,705.0	22,516,503.9	3,381,798.9
Биет бус хөрөнгө	93,062.3	93,421.2	258.9
Үндсэн хөрөнгийн элэгдэл	(7,722,313.8)	(8,982,629.1)	(1,260,315.3)
Нийт хөрөнгө	13,034,264.3	16,905,250.3	3,870,986.0
Өр төлбөр	31,228.4	20,588.7	(10,639.7)
Засгийн газрын хувь оролцоо	13,003,035.9	16,884,661.6	3,881,625.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	13,034,264.3	16,905,250.3	3,870,986.0

Урьдчилгаа тооцоо дансны үлдэгдэл 528,933.1 мянган төгрөг болж өссөн нь эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах тендерийг оны сүүлээр зохион байгуулж, гэрээний төлбөрийг урьдчилан төлсөн боловч эм, эмнэлгийн багаж хэрэгслийг гэрээний хугацаанд хүлээн аваагүйгээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 2,747,329.5 мянган төгрөг болж 1,220,314.6 мянган төгрөгөөр өссөн нь Ковид-19 цар тахлын үед эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар болон төсөл хөтөлбөрүүдээс хандив тусламжаар хүлээн авсан эм эмнэлгийн хэрэгсэл, өөрийн эх үүсвэрээр тасаг, лабораториудад эм эмнэлгийн хэрэгсэл, аж ахуй хангамжийн материалын нөөц бүрдүүлснээс шалтгаалжээ.

Энэ нь агуулахад 620,345.9 мянган төгрөг, тасгуудад 36,077.1 мянган төгрөг, лабораториудад 643,152.7 мянган төгрөг нийт эм, эмнэлгийн хэрэгсэл 1,299,575.7 мянган төгрөг, 1,447,753.8 мянган төгрөгийн аж ахуй хангамжийн бараа материалын үлдэгдэл байна. МОН-8 төслийн хүрээнд цөмийн оношилгооны тасагт бэлтгэж хүлээлгэн өгсөн 443,504.8 мянган төгрөг, Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар болон хандив тусламжаар хүлээн авсан 186,301.5 мянган төгрөг, өөрийн эх үүсвэрээр худалдан авсан 1,447,753.8 мянган төгрөгийн аж ахуйн хангамжийн материал, 669,769.4 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн үлдэгдэл байна. Ковид-19 цар тахлын улмаас Эрүүл мэндийн сайдын 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн А/99 тушаал, 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 23 тоот албан даалгаврын дагуу эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэх жагсаалт гарган худалдан авалт хийсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 22,516,503.9 мянган төгрөг болж 3,381,798.9 мянган төгрөгөөр өссөн нь Ковид-19 цар тахлын үед Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар болон төсөл хөтөлбөрөөс үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө хүлээн авснаас шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь хөрөнгө оруулалтаар 333,902.6 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 210,627.8 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 2,985,296.6 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө ТӨБЗГ-ын 2020 оны 3 дугаар сарын А1/453, 110, 9 дүгээр сарын 460 дугаар тогтоолуудыг үндэслэн 147,108.8 мянган төгрөгийн акталсан хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгө дансны үлдэгдэл 93,421.2 мянган төгрөг болж 358.9 мянган төгрөгөөр өссөн нь санхүүгийн программын үйлчилгээний хөлсийг капиталжуулснаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 20,588.7 мянган төгрөг болж 10,639.7 мянган төгрөгөөр буурсан нь 2020 онд төгссөн резидент эмч нарын төлбөрийг хүлээн зөвшөөрсөнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд 2019 – 2021 онуудын 17,216.0 мянган төгрөгийн барьцаа хөрөнгө, нийт өр төлбөрийн 83.6 хувийг эзэлж байна.

Бусад 3,372.7 мянган төгрөгийн өр төрийн сангийн гүйлгээ хаагдсанаас хойш өвчтөнд цус хэрэглэх зайлшгүй шалтгаанаас үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 16,884,661.6 мянган төгрөг болж 3,881,625.7 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх онд Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5 төслийн гүйцэтгэсэн барилга засварын ажлын санхүүжилтийг 2020 онд баримт бүрдүүлэн ирүүлснийг залруулан бүртгэсэн 340,807.6 мянган төгрөг, тайлант оны цэвэр ашиг 3,540,818.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс шалтгаалжээ. Энэ нь хуримтлагдсан алдагдлыг өмнөх үеийнхээс 3,881,625.6 мянган төгрөгөөр бууруулсан байна.

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 6,198,623.5 мянган төгрөгөөр буюу 35 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс үндсэн үйл ажиллагааны орлого, хандив тусламжийн орлого, төсвийн урсгал болон нэмэлт санхүүжилтийн орлого материаллаг хэмжээгээр өссөн өөрчлөлт гарсан байна. Энэ нь МОН-Т8 төсөл хэрэгжиж эмчилгээ оношилгооны шинэ төв ашиглалтанд орсонтой холбоотой эмнэлгийн тусламж, үйлчилгээний тоо нэмэгдэж үндсэн үйл ажиллагааны орлого 605,348.4 мянган төгрөгөөр, Ковид-19 цар тахлын үед Засгийн газрын хэлэлцээрийн дагуу хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр, дотоодын байгууллага, хувь хүмүүсийн үзүүлсэн хандив тусламж болон эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалт 1,133,224.7 мянган төгрөгөөр, эмчилгээ оношилгооны төв ашиглалтад орж байгаатай холбоотой ашиглалтын зардал, ажиллагсдын цалин хөлс, шинэ тоног төхөөрөмж худалдан авах зардал нэмэгдсэнтэй холбоотой урсгал үйл ажиллагааны төсвийн санхүүжилт 2,074,319.4 мянган төгрөгөөр, цар тахлын үед эмч эмнэлгийн ажилтнуудын урамшуулалт цалин, онц шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах тусламж, багцын шинжилгээнд зориулж ОБЕГ, ЭМДЕГ-аас олгосон санхүүжилтийн улмаас нэмэлт санхүүжилтийн орлого 292,114.9 мянган төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нийт зардал өмнөх оноос 4,693,312.1 мянган төгрөгөөр буюу 26.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн болон нэмэгдэл цалин, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл, ашиглалтын зардал, хангамж бараа материал, нормативт зардал, урсгал шилжүүлгийн зардлууд байна. Энэ нь эмчилгээ оношилгооны төвд ажиллагсдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, төвийн барилгын дулаан цахилгаан, усны зардлууд нэмэгдсэн, өвчтөн эмчлүүлэгчдийн тоо өссөнтэй холбоотой эм, эмнэлгийн хэрэгсэл, хоол хүнсний зардлууд өссөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан 340,807.6 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга нь Эрүүл мэндийн хөгжил хөтөлбөр-5 төслийн санхүүжилтээр 2019 онд Ариутгал нян судлалын лабораторид хийсэн барилгын

засварын ажлын санхүүжилтийн бичиг баримтыг бүрдүүлэн 2020 онд тус эмнэлэгт нөхөн хүлээлгэж өгснөөс шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 20,619,351.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 20,619,351.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 2021 оны 4, 7, 10, 12 дугаар саруудад 1,134,077.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 21,753,429.4 мянган төгрөг болгон төсвийн зохицуулалт хийгдсэн байна. Санхүүжилтийн эх үүсвэр өнгөрсөн оноос нийт 4,753,511.0 мянган төгрөгөөр нэмж баталсан нь эмчилгээ оношилгооны төвөөр үйлчлүүлэгсэд нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант оны батлагдсан төсвөөс орлогын гүйцэтгэл нийт дүнгээр 2,562,114.7 мянган төгрөгөөр тасарч, 88.2 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, халдвартай өвчтөнд эмнэлгийн тусламж үзүүлэх Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/99 тоот албан бичгийн дагуу 250 ор бэлтгэн бэлэн байдлыг ханган ажиллахтай холбоотой 2020 оны 2-6 дугаар сард, ПЭТ-КТГ, циклотроны үйлдвэрийг нээхтэй холбоотой 10-11 дүгээр сард эмчилгээ, оношилгооны төвийг бүрэн хаасан, 2020 оны 11 дүгээр сарын 6-ны өдрөөс А/520 тушаалын дагуу өндөржүүлсэн бэлэн байдалд шилжин ажилласантай холбоотой эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгсэд болон үйлчлүүлэгчдийн тоо буурсантай холбоотой байна. Орлогыг төрлөөр харуулбал:

- Урсгал төсвийн санхүүжилтийг өмнөх оны баталсан төсвөөс 2,100,569.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталж, тайлант оны баталсан төсвөөс 44,988.2 мянган төгрөгөөр тасарч, 99.3 хувийн гүйцэтгэлтэй,
- Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг өмнөх оны баталсан төсвөөс 2,346,798.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталж, тайлант оны баталсан төсвөөс 1,621,052.4 мянган төгрөгөөр тасарч, 86.8 хувийн гүйцэтгэлтэй,
- Өөрийн үйл ажиллагааны орлогыг өмнөх оны баталсан төсвөөс 3,082,452.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталж, тайлант оны баталсан төсвөөс 896,074.2 мянган төгрөгөөр тасарч, 72.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 21,753,429.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 6,254,760.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 12,291,424.5 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 3,207,244.8 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 6,228,510.1 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 10,670,372.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 2,311,170.7 мянган төгрөг, нийт 19,191,314.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 19,191,314.7 мянган төгрөгийг зарцуулж 18,738.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 19,191,314.7 мянган төгрөг буюу 88.2 хувьтай байгаа нь үндсэн болон нэмэгдэл цалингийн зардлыг 372,928.9 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 115,582.5 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой

тогтмол зардлыг 29,300.4 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 24,392.1 мянган төгрөг, нормативт зардлыг 925,490.5 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 2,495.5 мянган төгрөг, томилолт зочны зардлыг 1,595.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 5,753.1 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэл дадлагын зардлыг 18,091.9 мянган төгрөг, урсгал засварын зардал 26,250.0 мянган төгрөг, өндөр өртөгт эм эмнэлгийн хэрэгслийн зардлыг 1,031,225.6 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь Эмнэлгийн тусламж үйлчилгээний хөтөлбөрийн Бараа, үйлчилгээний зардал арга хэмжээ 1,504,639.1 мянган төгрөгөөр, Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил арга хэмжээ 26,250.0 мянган төгрөгөөр, Өндөр өртөгтэй эм, эмнэлгийн хэрэгслийн зардал арга хэмжээ 1,031,225.6 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 374,496.5 мянган төгрөгийн нэмэлт орлогыг бүрдүүлсэн байна. Үүнд:

- Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтээр хэрэгжүүлэх 2 төслийн 82,099.3 мянган төгрөг
- Эрүүл мэндийн хөгжлийн төвийн санхүүжилтээр резидентийн сургалтын төлбөр 30,643.2 мянган төгрөг
- Онцгой байдлын ерөнхий газраас диализын аппарат авахад 120,000.0 мянган төгрөг, эмч мэргэжилтнүүдийн урамшуулалд 18,000.0 мянган төгрөг
- Ковид-19 цар тахлын хүрээнд Эрүүл мэндийн яамнаас эмч мэргэжилтнүүдийн цалин урамшуулалд 27,300.0 мянган төгрөг, нэмэлт санхүүжилт 30,000.0 мянган төгрөг
- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас багцын шинжилгээний санхүүжилтэд 66,454.0 мянган төгрөг

Үүнээс цалин урамшуулалд 60,465.2 мянга, хангамжийн бараа материалд 42,890.1 мянга, эмийн зардалд 78,013.2 мянга, тоног төхөөрөмж, тавилга эд хогшилд 139,584.2 мянга, бусад бараа ажил үйлчилгээний зардалд 52,353.8 мянга, нэг удаагийн тэтгэмжид 1,190.0 мянга, нийт 374,496.5 мянган төгрөгийг зарцуулжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 155 мэдээллээс хугацаандаа оруулсан 152 мэдээлэл, хугацаа болоогүй 3 мэдээлэл, хугацаа хоцроож байршуулсан 2 мэдээлэл байна.

2020 оны 8 дугаар сард эрх нээсэн Ковид-19 цар тахалтай холбоотой 187,300.0 мянган төгрөгийн мөнгөн хандив тусламжийн орлого, 222,330.3 мянган төгрөгийн материаллаг хандив, тусламжийн орлого, нийт 406,593.3 мянган төгрөгийн

зарцуулалтын 1-9 сарын мэдээнүүдийг хугацаа хоцроож, 10 дугаар сард нөхөн оруулсан зөрчил байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 111,698.0 мянган төгрөгийн зөрчилд өгсөн 2,525.7 мянган төгрөгийн төлбөрийн акт, 106,100.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 3,072.3 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	2,525.7	1	2,525.7	-	-	
Албан шаардлага	1	106,100.0	1	106,100.0	-	-	
Зөвлөмж	2	3,072.3	2	3,072.3	-	-	
Нийт дүн	4	111,698.0	4	111,698.0	-	-	

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,238,630.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 5,083.8 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 1,223,465.8 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 10,080.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын 44,650.3 мянган төгрөгийн алдааг залруулаагүй.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 1,228,549.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 5,083.8 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1,223,465.8 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Багш нарын цалин 21,182.4 мянган төгрөгийг НДШ-ийн тайланд тайлагнаагүй, тооцох 5,083.8 мянган төгрөгийн шимтгэлийг төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17.1.1-д “хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” гэсэн заалттай нийцэхгүй, хэмжилт, эрх ба үүрэг, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2. Үйл ажиллагааны орлого нийт дүнгээр 896,074.2 мянган төгрөгөөр тасарч, 72.1 хувийн гүйцэтгэлтэй. нэмэлт санхүүжилтээс 4,441.7 мянган төгрөгийг нээсэн эрхийн дагуу зарцуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.2.3-д “урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал

нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв, эрх ба үүрэг, ангилал, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

3. Эрүүл мэндийн даатгалын сангаас орлогыг зардал хэтрүүлсэн, хугацаа хоцроосон, баримтыг буруу бүрдүүлсэн зэрэг шалтгаанаар хасаж санхүүжүүлсэн 41,629.2 мянган төгрөгийг орлого бууруулан бүртгэсэн, хэвтэн эмчлүүлэгсдийн дутуу төлбөрийг аккрузль сууриар бүртгээгүйгээс 3,021.1 мянган төгрөгийн орлогыг тус тус хүлээн зөвшөөрөөгүй, авлага үүсгээгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузль сууриар хөтөлнө”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв, эрх ба үүрэг, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

4. Тайлант хугацаанд урсгал төсвийн хөрөнгөөр худалдан авсан 210,627.8 мянган төгрөгийн хөрөнгүүдийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хандан бүртгэх зөвшөөрөл аваагүй байна.

Тус эмнэлгийн дүн бүртгэлд 2015-2019 онд ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар E-Health программыг хүлээн авч ашиглаж байсан боловч биет бус хөрөнгөөр бүртгэж тайлагнаагүй. 2019 оны 12-р сараас ЭМЯ-наас Карте программыг ашиглах чиглэл өгсөн ч орлогод бүртгэх шийдвэр ирүүлээгүй, 2020 оны тайланд хөрөнгөөр бүртгээгүй байна. 2020 оны эцэст Биет бус хөрөнгөнд 17 нэр төрлийн 93,421.2 мянган төгрөгийн программ бүртгэлтэй байгаагаас цаг бүртгэл, даатгал, флюграфийн программууд тус бүр 2, нүдний эмчилгээнд зориулалттай 3 программ байна. Үүнээс 67,671.8 мянган төгрөгийн 11 программ нь ашиглагдахгүй болсон байна. Шинээр программ худалдаж авахдаа өмнөх программын ашиглалтын чанар, хэрэглээг тодорхойлж, судлаагүй, ижил зориулалттай хөрөнгүүдийг давхардуулан худалдаж авсан байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 4.2-т “төсөвт хуулийн этгээд нь Төсвийн тухай хуулийн батлагдсан урсгал төсөв, хэмнэсэн төсөв болон давсан орлогоос үндсэн хөрөнгө бэлтгэх бол хэрэгцээ, шаардлагаа тодорхойлж, зайлшгүй хэрэгцээтэй хөрөнгийн жагсаалт, тоо хэмжээ, худалдан авах үнийн дээд хязгаарын саналыг дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагч дэмжсэн тохиолдолд төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зөвшөөрөл олгоно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4-д Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, УСНББОУС-31.28-д “хөрөнгөтэй холбоотой эдийн засгийн ирээдүйн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг байгууллага хүртэх магадлалтай бол хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв, эрх ба үүрэг, тохиолдсон байх, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

5. Шилэн дансны цахим сайтад 2020 оны 8 дугаар сард эрх нь нээгдсэн цэсэнд Ковидтай холбоотой 187,300.0 мянган төгрөгийн мөнгөн хандив тусламжийн

орлого, 222,330.3 мянган төгрөгийн материаллаг хандив, тусламжийн орлого, нийт 406,593.3 мянган төгрөгийн зарцуулалтын 1-9 сарын мэдээнүүдийг хугацаа хоцроож, 10 дугаар сард нөхөн оруулсан.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв, эрх ба үүрэг, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 10,080.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Улсын хоёрдугаар төв эмнэлэг 2019 оны 12 дугаар сараас Аксис систем ХХК-ийн Карте программыг эмчилгээ, үйлчилгээний бүртгэлийн системд нэвтрүүлж эхэлсэн байна. Тус программд хэвтэн эмчлүүлэгсдийн өвчтөний түүхийг бүртгэдэг болсон тул эм, эмнэлгийн хэрэгслийн захиалга эм зүйн албанд шууд очиж байна. Гэвч программын хэрэглээг хянаж, сайжруулах ажил хэлтэс, нэгжүүдийн хооронд уялдаа муутай байгаагаас шалтгаалан эм зүйн захиалгын хавсралт падаан дээр өвчтөний нэр үсгээр тэмдэглэгдэн гарсан алдаануудыг засаагүй байна. Эрүүл мэндийн даатгалын албанд хадгалагдаж байгаа өвчтөний түүхүүд бүртгэлгүй, эм зүйн албаны эмийн зарлагын тайлантай тулган шалгахад өвчтөний түүхүүд дутуу, тухайн сард сонгосон тасгийн өвчтөний хэдэн түүх байх ёстойгоос хэд нь байгаа, хэдэн түүхийг эмч нар эрдэм шинжилгээний зориулалтаар авсан, хэдэн түүх нас барсан шалтгаанаар өөр газарт татан авсан зэрэг нарийн бүртгэлгүй таамгаар тайлбар өгч байсан. Эмийн зарлагыг нягтлан бодох бүртгэлд тусгахдаа эм зүйн албаны түүврийн нэгтгэлийг үндэслэн бүртгэж, Карте программын анхан шатны бүртгэлтэй тулгаж хянаагүй, бүртгэлээр тавих хяналт сул, эрсдэлтэй байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаатай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн даргын 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/98 дугаар тушаалаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж, батлуулсан. Дээрх бодлогын баримт бичигт:

- 4.3.1.5.Б-д Бараа материалын зарлагын бүртгэлийн журналын бичилтэд эм эмнэлгийн хэрэгслийн төв агуулахаас эм зүйд, эм зүйгээс тасаг нэгжид, тасаг нэгжийн бараа материалын зардлыг гүйцэтгэлээр хүлээн зөвшөөрөх талаар тусгаагүй, эм зүйгээс олгосон дүнгээр шууд зардалд хүлээн зөвшөөрч бүртгэсэн.
- 4.4.1.7.-д Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох хугацааг тогтоохдоо анги бүлгүүдийн нэрийг хэт ерөнхий зааж, интервалтай тогтоосон байна. Компьютер дагалдах хэрэгслийн ашиглах хугацааг 4-6 жил байхаар тогтоосон ч бүртгэлд сүүлийн хугацаанд орлого авсан хөрөнгүүдийг 2-3 жилээр тогтоон элэгдлийг бүртгэсэн.
- 4.2.2.4-д үйлчилгээний орлогыг нэхэмжилсэн дүнгээр авлагаар хүлээн зөвшөөрч, мөнгөөр төлөгдсөн үед авлагыг хааж бүртгэхээр тодорхойлсон боловч эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжилсэн орлогыг төлөгдсөн дүнгээр нь хүлээн зөвшөөрч, даатгалаас хэтэрсэн болон програмын алдаанаас үүссэн хувь хүнээс нэхэмжлэн авах орлогыг авлагаар тайлагнаагүй.

1.2. Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг 1 хувь байгаа нь зарим шалгалтын ажилтнуудын шаардсаны дагуу үзүүлбэр болгон ашиглах, өөрийн байгууллагад мөрдөх дүрэм, журам, хууль, стандартыг баримтлаагүй нь бүртгэл, санхүүгийн ажилтнуудад гарын авлага болоогүй, бүртгэлээр тавих хяналт сул байх

1.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйл, 18.2-д “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллах”, УСНББОУС-3.7-д “нягтлан бодох бүртгэлийн бодлого гэдэг нь санхүүгийн тайланг бэлтгэх болон толилуулахад байгууллагын хэрэглэж буй тусгай зарчим, суурь, дүрэм, журам ба практик үйл ажиллагаа юм” гэсний дагуу өөрийн байгууллагын нягтлан бодох бүртгэл, тайлагналд нийцүүлэн, санхүүгийн ажилтнууд гарын авлага, заавар болгон ашиглаж, дагаж мөрдөхөөр болгон сайжруулах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

2018 онд төрийн өмчид дахин үнэлгээ хийгдэх ажил зохион байгуулагдаж, манай байгууллага зарим компьютер дагалдах хэрэгслийн(ашиглах хугацаа дууссан) ашиглах жилийг 2-3 жилээр нэмэгдүүлсэн. Энэ нь мөрдөгдөж буй бодлогын бичиг баримттай зөрчилдсэн байна. 2020 онд бодлогын бичиг баримтын дагуу элэгдэл зөв тооцогдсон.

2. Нягтлан бодох бүртгэлийн програм, хангамжтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Эмчилгээ, тусламжийн үйлчилгээний бүртгэлд Аксис систем ХХК-ийн Карте программыг ашиглаж байна. Аудитын түүвэрт Компьютер томограф, рентген зураг, хэт авианы дүрс оношилгооны лабораторуудын 2020 оны 5 дугаар сар, Мэс заслын 1, 2 дугаар тасаг, MRI шинжилгээний лабораторийн 11 дүгээр сарын орлогын бүртгэлийг хамруулан Карте программын анхан шатны бүртгэлийг, нягтлан бодох бүртгэлийн журналтай тулган шалгахад 8,187.9 мянган төгрөгийн зөрүүтэй байна.

Мөн өвчтөн, эмчлүүлэгсдийн эрүүл мэндийн даатгалын бүртгэлийг буруу бүртгэсэн, тухай бүр нь хяналт тавиагүйгээс ЭМДЕГ-аас нэхэмжилсэн санхүүжилтийн дүн 44,650.3 мянган төгрөгийн зөрүүтэй байна.

Нягтлан бодох бүртгэлийн Емералд программаас мөнгөн хөрөнгийн дансны хуулга мэдээнд эдийн засгийн ангиллын код, харилцагч байгууллагын нэр татагддаггүй бол баримтын жагсаалтаарх мэдээнд харьцсан дансны мэдээлэл гарахгүй байгаа нь төсөвт байгууллагын төсвийн гүйцэтгэлийн бүртгэл, мэдээний шаардлага хангаагүй, түүнд бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байна.

Тус эмнэлэгт ашиглаж байгаа эдгээр программууд нь 1 жилээс дээш ашиглагдаж байгаа хэдий ч ашиглалт, хөгжүүлэлт хангалтгүй, хариуцсан ажилтнууд гарч байгаа мэдээ тайлангийн чанар хэрэглээнд тавигдах шаардлагыг хангуулаагүй байна.

2.2. Эрсдэл:

Дээрх программууд нь тус тусдаа үйл ажиллагааг бүртгэж, тайлагнадаг хэдий ч нягтлан бодох бүртгэл хөтлөлт анхан шатны бүртгэлүүдтэй уялдаа холбоогүй, бүртгэлээр тавих дотоод хяналт сул байх

2.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл, 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, УСНББОУС-1.27 дугаар заалт “санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой”-д нийцүүлэн эмнэлгийн бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэж байгаа програмуудын ашиглалт хэрэглээг сайжруулах, гарч байгаа мэдээ тайлангийн үнэн зөв байдалд дотоод хяналт тавих

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

2019 оны 12 сараас хэрэгжиж буй эрүүл мэндийн Карте программын мэдээ, тайлан ,санхүүгийн программтай тулгахад зөрүүтэй байгаа нь уг программыг албан ёсоор хүлээлгэж өгөөгүй туршилтын маягтай явж байгаа нь ажилд хүндрэл учруулж байгаа үнэн.

3. Худалдан авалт болон гэрээний хэрэгжилтийн талаарх асуудал

3.1. Илрүүлэлт:

Эмнэлгийн жижиг багаж хэрэгсэл 700,000.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны баримт бичгүүдийг аудитад шалгуулахаар ирүүлэхдээ хугацаа сунжруулах, санхүүжүүлэх эх үүсвэртэй холбоотой баримтыг нэг ажилтан, гэрээ түүнтэй холбоотой баримтуудыг өөр нэг ажилтан хариуцан гаргаж өгч байсан. Мөн хариуцсан ажилтан хөл хорионд орсон үед өөр ажилтан орлон гүйцэтгэх, хугацаа алдалгүй зохион байгуулах ажлууд дутмаг байна.

Асуудлын бүртгэл танилцуулсны дараа Эрүүл мэндийн яамнаас баталсан төсөв, гэрээ хийсэн байгууллагуудын 528,600.3 мянган төгрөгийн хөрөнгийн барьцаа, тооцоо нийлсэн актууд, худалдан авах ажиллагааны цахим сайтад мэдээлсэн нийлүүлэлтийн хуваарийн дагуу сунгасан гэрээнүүдийг ирүүлсэн.

3.2. Эрсдэл:

Зарим алба нэгж, ажилтнуудын ажлын зохион байгуулалт муу, ажил үүрэг гүйцэтгэх уялдаа холбоо тааруу байгаа нь байгууллагын үйл ажиллагааг буруу танилцуулж, түүнээс үүдэн буруу дүгнэлт гарах

3.3. Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, хуулийн 46 дугаар зүйлийн хэрэгжилтийг сайжруулах, Эрүүл мэндийн яам болон бусад холбогдох байгууллагуудаас тушаал шийдвэрүүдийг цаг алдалгүй шаардан авч, баримт бүрдүүлэлтийг хангаж ажиллах, алба нэгж, ажилтнуудын үүрэг хариуцлагыг сайжруулах, цаашид алдаа дутагдлыг давтан гаргахгүй ажиллах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Худалдан авах ажиллагааг зохион байгуулах санхүүжилтийн эх үүсвэрийг 10 дугаар сард төсвийн тодотгол хийж улсын төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлсэн болно. өсвийн тодотгол хийгдсэнээр 2020 оны ХАА-ны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах хүсэлтийг Сангийн сайдын 2018 оны 281 тоот тушаалын хавсралт журмын дагуу ХАА-ны төлөвлөгөөнд нэмэлт оруулан баталгаажуулж 10 дугаар сарын 23-ны өдөр тендер шалгаруулалтыг зохион байгуулж зарласан болно.

Тооцоо нийлсэн актыг асуудлын бүртгэл танилцуулсны дараа нэмж хүргүүлсэн. Гэрээний дүгнэлт хийгдээгүй байгаа. Зарим төхөөрөмж хил, гааль ажиллаагүйтэй холбоотой нийлүүлэгдээгүй байна. Гэрээний хугацаанд цаг үеийн байдлаас шалтгаалан нийлүүлэлт хугацаандаа хийгдэх боломжгүй эрсдлийг тооцон гэрээний тусгай нөхцөлд зааснаар гэрээний үнийн дүн бүхий урьдчилгаа төлбөрийн баталгааг гаргуулж авсан болно. /Урьдчилгаа төлбөрийн баталгаа хавсаргав/

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	УХТЭ-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
20..			САГ-2021/55/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:		Улсын хоёрдугаар тав эмнэлэг	Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	6
1	Багш нарын цалин 21,182.4 мянган төгрөгийн цалин, ажлын хөлсийг НДШ-ийн тайланд тайлагнаагүй, тооцох шимтгэлийг төсөвт төвлөрүүлээгүй байна.	5,083.8	Акт тогтоох	УХТЭ-ийн Эмчилгээ эрхэлссэн захирал Ахлах нягтлан бодогч	Ц.Ганзориг А.Байгальсүрэн
2	Үйл ажиллагааны орлого нийт дүнгээр 896,074.2 мянган төгрөгөөр тасарч, 72.1 хувийн гүйцэтгэлтэй, нэмэлт санхүүжилтээс 4,441.7 мянган төгрөгийг нээсэн эрхийн дагуу зарцуулаагүй байна	900,515.9	Албан шаардлага	УХТЭ-ийн Эмчилгээ эрхэлссэн захирал Ахлах нягтлан бодогч	Ц.Ганзориг А.Байгальсүрэн
3	Эрүүл мэндийн даатгалын сангаас орлогыг зардал хэтрүүлсэн, хугацаа хоцроосон, баримтыг буруу бүрдүүлсэн зэрэг шалтгаанаар хасч санхүүжүүлсэн 41,629.2 мянган төгрөгийг орлого бууруулан бүртгэсэн, хэвтэн эмчлүүлэгсдийн дутуу төлбөрийг аккруэль сууриар бүртгээгүйгээс 3,021.1 мянган төгрөгийн орлогыг тус тус хүлээн зөвшөөрөөгүй, авлага үүсгээгүй.	44,650.3	Албан шаардлага	УХТЭ-ийн Эмчилгээ эрхэлссэн захирал Ахлах нягтлан бодогч	Ц.Ганзориг А.Байгальсүрэн
4	Тайлант хугацаанд урсгал төсвийн хөрөнгөөр худалдан авсан 210,627.8 мянган төгрөгийн хөрөнгүүдийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хандан бүртгэх зөвшөөрөл аваагүй байна. Тус эмнэлгийн дүн бүртгэлд 2015-2019 онд ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар E-Health програмыг хүлээн авч ашиглаж байсан боловч биет бус хөрөнгөөр бүртгэж тайлагнаагүй. 2019 оны 12-р сараас ЭМЯ-наас Карте програмыг ашиглах чиглэл өгсөн ч орлогод бүртгэх шийдвэр ирүүлээгүй, 2020 оны тайланд хөрөнгөөр бүртгээгүй байна. 2020 оны эцэст Биет бус хөрөнгөнд 17 нэр төрлийн 93,421.2 мянган төгрөгийн програм бүртгэлтэй байгаагаас цаг бүртгэл, даатгал, флюграфийн програмууд тус бүр 2, нүдний эмчилгээнд зориулалттай 3 програм байна. Үүнээс 67,671.8 мянган төгрөгийн 11 програм нь ашиглагдахгүй болсон байна. Шинээр програм худалдаж авахдаа өмнөх програмын ашиглалтын чанар, хэрэглээг тодорхойлж, судлаагүй, ижил зориулалттай хөрөнгүүдийг давхардуулан худалдаж авсан байна.	278,299.6	Албан шаардлага	УХТЭ-ийн Эмчилгээ эрхэлссэн захирал Ахлах нягтлан бодогч	Ц.Ганзориг А.Байгальсүрэн

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5	Шилэн дансны цахим сайтад 2020 оны 8 дугаар сард эрх нь нээгдсэн цэсэнд Ковидтай холбоотой 187,300.0 мянган төгрөгийн мөнгөн хандив тусламжийн орлого, 222,330.3 мянган төгрөгийн материаллаг хандив, тусламжийн орлого, нийт 406,593.3 мянган төгрөгийн зарцуулалтын 1-9 сарын мэдээнүүдийг хугацаа хоцроож, 10 дугаар сард нөхөн оруулсан.		Албан шаардлага	УХТЭ-ийн Эмчилгээ эрхэлссэн захирал Ахлах нягтлан бодогч	Ц.Ганзориг А.Байгальсүрэн
6	НББ-ийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж мөрдөөгүй байна. Тухайлбал: компьютер дагалдах хэрэгслийн ашиглах хугацааг 4-6 жил гэж тогтоосон боловч НББ-д 2018 оноос хойш авсан хөрөнгүүдийг 2-3 жилээр ашиглах хугацааг тогтоон элэгдлийн зардлыг өсгөсөн, богино хугацаанд ашиглан данснаас хасч хөрөнгийг үнэгүйдүүлэх эрсдэлтэй байна.	1,892.8	Зөвлөмж өгөх	УХТЭ-ийн Эмчилгээ эрхэлссэн захирал Ахлах нягтлан бодогч	Ц.Ганзориг А.Байгальсүрэн
7	Аудитын түүвэрт хамруулсан мэс заслын 1, 2 дугаар тасаг болон MRI шинжилгээний 11 дүгээр сарын орлого, КТГ, Рентген зураг, Эхо шинжилгээний 5 дугаар сарын орлогыг НББ-ийн Емералд програмын орлогын журналын дүнгээс Карте програмын тухайн сарын орлогын мэдээнүүдтэй тулгахад нийт дүнгээр 8,187.8 мянган төгрөгөөр зөрүүтэй. Карте програмд өвчтөний түүхээс эм, эмнэлгийн хэрэгслийн захиалга бүртгэгдэж, эм зүйн албаны татсан тайланд өвчтөний нэрүүд Л, Б, Д гэсэн үсгээр тэмдэглэгдсэнийг 2 албад тулгаж, шалгаагүй, алдаатай байгаа тул өвчтөний түүхтэй тулгах боломжгүй байна.	8,187.8	Зөвлөмж өгөх	УХТЭ-ийн Эмчилгээ эрхэлссэн захирал Ахлах нягтлан бодогч	Ц.Ганзориг А.Байгальсүрэн
8	Эмнэлгийн жижиг багаж хэрэсэл 700,000.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны баримт бичгүүдийг аудитад шалгуулахаар ирүүлэхдээ хугацаа сунжруулах, санхүүжүүлэх эх үүсвэртэй холбоотой баримтыг нэг ажилтан, гэрээ түүнтэй холбоотой баримтуудыг өөр нэг ажилтан хариуцан гаргаж өгч байсан. Мөн хариуцсан ажилтан хөл хорионд орсон үед өөр ажилтан орлон гүйцэтгэх, хугацаа алдалгүй зохион байгуулах ажлууд дутмаг байна. Асуудлын бүртгэл танилцуулсны дараа Эрүүл мэндийн яамнаас баталсан төсөв, гэрээ хийсэн байгууллагуудын 528,600.3 мянган төгрөгийн хөрөнгийн барьцаа, тооцоо нийлсэн актууд, худалдан авах ажиллагааны цахим сайтад мэдээлсэн нийлүүлэлтийн хуваарийн дагуу сунгасан гэрээнүүдийг ирүүлсэн.	-	Зөвлөмж	УХТЭ-ийн Эмчилгээ эрхэлссэн захирал Ахлах нягтлан бодогч	Ц.Ганзориг А.Байгальсүрэн
ДҮН		1,238,630.2			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2021 оны 02 дугаар сарын 05 № 51/А0170079
САГ-0021/55/СТА-ТЦЗ
Төлбөр барагдуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Багш нарын цалин 21,182.4 мянган төгрөгийг НДШ-ийн тайланд тайлагнаагүй, 5,083.8 мянган төгрөгийн шимтгэлийг тооцож, төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17.1.1-д "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нийгмийн даатгалын тайланд тайлагнаагүй 21,182.4 мянган төгрөгийн цалингийн зардал түүнээс суутган тооцох 2,436.0 мянган төгрөгийг ажилчдаас авлага үүсгэн, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 2,647.8 мянган төгрөгөөр тооцон бүртгэж, нийт 5,083.8 мянган төгрөгийн шимтгэлийн дүнгээр харьяа дүүргийн нийгмийн даатгалын байгууллагад өглөг үүсгэн бүртгэж, нөхөн тайлан гаргаж тушаах, биелэлтийг 2021 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөр 5,083.8 мянган төгрөгийг Баянзүрх дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн Төрийн сан дахь 1002003940000 тоот дансанд 2021 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор төвлөрүүлэхийг Улсын хоёрдугаар төв эмнэлгийн Эмчилгээ эрхэлсэн орлогч захирал Ц.Ганзориг, Ахлах нягтлан бодогч А.Байгалсүрэн нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Э.ЭНХБААТАР
Н.ДЭЛГЭРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Akt\2021\0225auditin 2-R Газар20.Docx

001090542



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 79/АО/70079

Улаанбаатар хот

СЭГ-2021/40/СТА-7ХН

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд урсгал төсвийн хөрөнгөөр худалдан авсан 210,627.8 мянган төгрөгийн хөрөнгүүдийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хандан бүртгэх зөвшөөрөл аваагүй байна.

Тус эмнэлгийн дүн бүртгэлд 2019 оны 12 дугаар сараас Аксис систем ХХК-ийн Карте програмыг ашиглаж, орлогоор бүртгээгүй, 2020 оны тайланд хөрөнгөөр тайлагнаагүй байна. 2020 оны эцэст Биет бус хөрөнгөнд 17 нэр төрлийн 93,421.2 мянган төгрөгийн програм бүртгэлтэй байгаагаас цаг бүртгэл, даатгал, флюграфийн програмууд тус бүр 2, нүдний эмчилгээнд зориулалттай 3 програм байна. Үүнээс 67,671.8 мянган төгрөгийн 11 програм нь ашиглагдахгүй болсон байна. Шинээр програм худалдаж авахдаа өмнөх програмын ашиглалтын чанар, хэрэглээг тодорхойлж, судлаагүй, ижил зориулалттай хөрөнгүүдийг давхардуулан худалдаж авсан байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 4.2-т "төсөвт хуулийн этгээд нь Төсвийн тухай хуулийн батлагдсан урсгал төсөв, хэмнэсэн төсөв болон давсан орлогоос үндсэн хөрөнгө бэлтгэх бол хэрэгцээ, шаардлагаа тодорхойлж, зайлшгүй хэрэгцээтэй хөрөнгийн жагсаалт, тоо хэмжээ, худалдан авах үнийн дээд хязгаарын саналыг дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагч дэмжсэн тохиолдолд төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зөвшөөрөл олгоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4-д Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", УСНББОУС-31.28-д "хөрөнгөтэй холбоотой эдийн засгийн ирээдүйн үр өгөөж буюу үйлчилгээний чадавхийг

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264238

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban-Shaardiaga\2021\0225auditiin 2-R Gazar63.Docx

байгууллага хүртэх магадлалтай бол хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Биет бус хөрөнгийг хүлээн авсан цаг тухайд нь хүлээлгэн өгсөн тушаал шийдвэр, акт баримтыг үндэслэн хөрөнгөөр бүртгэж, хөрөнгө шамшигдахаас сэргийлэх, ашиглалтын хугацаа дууссан, хэрэгцээ шаардлага хангахгүй хөрөнгийг тухай бүр нь шийдвэр гаргаж данснаас хасах, программ хангамжийн нууцлал, аюулгүй байдлыг хангуулан хөгжүүлэлт, сайжруулалтыг цаг хугацаа алдалгүй хийлгэж, тогтвортой ашиглах, байгууллагын дүн бүртгэл, нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл, тайлагналын чанар, ашиглалтыг сайжруулах, биелэлтийг 2021 оны 6 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх
1. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын хоёрдугаар төв эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн орлогч захирал Ц.Ганзориг, Ахлах нягтлан бодогч А.Байгальсүрэн нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Э.ЭНХБААТАР

Н.ДЭЛГЭРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 80/А0170079
СНГ- 2021/40/СТА-ТХН

Улаанбаатар хот

Г Зөрчил арилгуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийн даатгалын сангаас орлогыг зардал хэтрүүлсэн, хугацаа хоцроосон, баримтыг буруу бүрдүүлсэн зэрэг шалтгаанаар хасч санхүүжүүлсэн 41,629.2 мянган төгрөгийг орлого бууруулан бүртгэсэн, хэвтэн эмчлүүлэгсдийн төлбөрийг аккрузль сууриар бүртгээгүйгээс 3,021.1 мянган төгрөгийг тус тус орлогоор хүлээн зөвшөөрөөгүй, авлага тайлагнаагүй байна

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузль сууриар хөтөлнө", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" Сангийн Сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан журмын 3.12-д "Найдваргүй авлагыг бүртгэхдээ авлагыг хорогдуулах хэмжээ, баримтлах зарчим, нөхцөлийг заасан эрх бүхий байгууллагын найдваргүй болсон авлагыг данснаас хасах тухай шийдвэрийг үндэслэнэ. Шийдвэр гартал уг найдваргүй болсон авлагыг санхүүгийн тайланд авлагаар тусгана. Төсөвт байгууллагууд найдваргүй авлагыг шууд аргыг хэрэглэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Орлогын бүртгэлийг аккрузль сууриар хүлээн зөвшөөрч, авлага үүсгэн бүртгэн тайлагнаж биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх
2. Цаашид ЭМДС-аас зардал хэтрүүлсэн, регистрийн дугаар буруу бүртгэсэн, хугацаа хоцроож нэхэмжилсэн орлогуудыг хасч санхүүжүүлсэн авлагыг барагдуулах талаар хариуцсан албан тушаалтнууд анхаарч ажиллах, Эрүүл мэндийн салбарт авлага үүсгэдэггүй гэсэн нийтлэг алдаа зөрчлийг арилгуулах, хууль журамд заасан нөхцөлтэй иргэдийн төлбөрийг чөлөөлөх тушаал шийдвэр гарсны дараа найдваргүй авлагыг данснаас хасах бүртгэлийг мөрдөж ажиллахыг Улсын хоёрдугаар төв эмнэлгийн Эмчилгээ эрхэлсэн орлогч захирал Ц.Ганзориг, Ахлах нягтлан бодогч А.Байгальсүрэн нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Э.ЭНХБААТАР

Н.ДЭЛГЭРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 31/АД/70079
САН-2021/40/СТА-ТХН
Зөрчил арилгуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын шилэн дансны цахим сайтад 2020 оны 8 дугаар сард эрх нь нээгдсэн цэсэнд Ковидтай холбоотой 187,300.0 мянган төгрөгийн мөнгөн хандив тусламжийн орлого, 222,330.3 мянган төгрөгийн материаллаг хандив, тусламжийн орлого, нийт 406,593.3 мянган төгрөгийн зарцуулалтын 1-9 сарын мэдээнүүдийг хугацаа хоцроож, 10 дугаар сард нөхөн оруулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг хугацаанд нь ил тод, бүрэн байршуулж биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын хоёрдугаар төв эмнэлгийн Эмчилгээ эрхэлсэн орлогч захирал Ц.Ганзориг, Ахлах нягтлан бодогч А.Байгальсүрэн нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Э.ЭНХБААТАР

Н.ДЭЛГЭРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 89/АД/ТӨД 79

Улаанбаатар хот

САГ- 2021/40/СТА-ТХМ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үйл ажиллагааны орлого нийт дүнгээр 896,074.2 мянган төгрөгөөр тасарч, 72.1 хувийн гүйцэтгэлтэй. Нэмэлт санхүүжилтээс 4,441.7 мянган төгрөгийг нээсэн эрхийн дагуу зарцуулаагүй зөрчил гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.2.3-д “урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн орлогыг зөв зохистой төлөвлөн, хэрэгжүүлж ажиллах, биелэлтийг 2021 оны 6 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын хоёрдугаар төв эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн орлогч захирал Ц.Ганзориг, Ахлах нягтлан бодогч А.Байгальсүрэн нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Э.ЭНХБААТАР

Н.ДЭЛГЭРМАА

